

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024.12.30

Шивээговь сум


№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	Гэрээлсэн дүн	Хэрэгжилт	Хувь
1. Шилжих хөрөнгө оруулалт				248,208,6	354,583,6		
1	Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /хөл бөмбөгийн талбай/ байгуулах ажил	1	2023-2024	248,208,6	354,583.6	Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 354,583,682 мянган төгрөгийн хөрөнгөөр Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /хөл бөмбөгийн талбай/ байгуулах ажлын техникийн тодорхойлолтыг баталж, сумын Засаг даргын А/122 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж, тус хорооны шийдвэрээр “Цагаан толгойн нуур” ХХК-г сонгон шалгаруулан 354,583,682 төгрөгийн гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр байгуулсан. Ажил 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэж гүйцэтгэл 50 хувьтай цаг агаарын нөхцөлөөс хамаарч ажил зогссон. 2024 оны үргэлжлэх ажил 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн гүйцэтгэгдсэн. Нийтийн биеийн тамирын талбай/хөл бөмбөгийн талбай/ байгуулах ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дууссан бөгөөд ажлыг хүлээн авах комиссыг сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээж авах комиссын бүрэлдэхүүн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээж авсан.	100


							
2. Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт							
2.1	Сургуулийн спорт заалны их засварын ажил	2	2024	179,150,0	171,821,1	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Сургуулийн спорт заалны их засварын ажлын төсвийг 179,150,000 төгрөгөөр баталсан. 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/11 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Нээлттэй тендерийг цахим сайтад 3 удаа зарласан. 4 дэх удаагийн зарлалтыг Техникийн тодорхойлолтыг шинэчлэн баталж дахин цахим зарласан. Тус тендерт “Хур билиг” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэн 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авч ЕБС-ийн 3 дугаар сургуульд хүлээлгэн өгсөн.</p> 	100



2.2	Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил	3	2024	235,400,0	234,491,1	<p>Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Хуучин хогийн цэг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил”-ын явц 100 хувийн гүйцэтгэлтэй дуусч 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авах комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээж авсан.</p> <p>Гэрээний нийт үнийн дүн: 234,491,141 төгрөг Гүйцэтгэгч: “СҮМБЭР ХИШИГ” ХХК</p> <p>Тендер зарлагдсан тоо хэмжээ 25,000 м3 хур хог хаягдлыг зөөвөрлөх, 2,100 м2 талбайг бульдозероор түрж тэгшлэх ажлын даалгавар өгөгдсөн. Бодит гүйцэтгэлээр 285,120 м3 хур хог хаягдлыг зөөвөрлөж, 190,850 м2 талбайг бульдозероор түрж тэгшилсэн байна.</p>	100
2.3	Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/	4	2024	276,500,0	276,001,3	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажлыг 276,500,000 төгрөгөөр баталсан.</p> <p>Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/15 дугаар захирамжаар үнэлгээний хороог байгуулсан бөгөөд техникийн тодорхойлолтыг боловсруулан 3 удаа цахимаар зарлаж амжилтгүй болсон. 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 4 дэх удаагаа зарлаж 30-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж</p>	100





					<p>үзээд “Их хайрханы хишиг” ХХК шалгарч 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж 2024 оны 09 дүгээр сарын 10 дугаар сарын 01-ний өдөр 100 хувийн гүйцэтгэлтэй дуусч Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус ажлын үр дүнд Төрийн албан хаагчдын 9 гэр бүл ая тухтай амьдрах орчин бүрдсэн. Мөн Сумын Засаг даргын Тамгын газрын дээвэр засварлагдаж ажиллах орчин бүрдсэн.</p>		
					 <p>“Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн шинэ байрны засвар</p>		
2.4	Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих	5	2024	160,000,0	148,348,6	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих ажлыг 160,000,000 төгрөгөөр төсвийг баталсан. 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/16 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Цахимд тендерийг зарлаж нээлт хийхэд “Монничикон трейд” ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан. Гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгэн 2024 оны 07 дугаар сарын 05-нд ажлыг хүлээн авах комисс ажиллаж дулааны шугамын холболттой холбоотой гэрээг сунгаж үлдэгдэл 3 хашааг бүрэн хийгдэж дуусахад дахин хяналт тавьхаар комиссын гишүүдийн үүрэг</p>	100


					<p>даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авч 3 дугаар цэцэрлэгт хүлээлгэн өгсөн. Дулааны шугам сүлжээний ажилтай холбогдуулан гэрээг сунгах хүсэлт ирүүлж 2024 оны 08 дугаар сарын 2-ны өдөр хүртэл сунгасан:</p>		
							
2.5	Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах	6	2024	60,000,0	59,003,4	<p>2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн ИТХ-ын 05 дугаар тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний тодотгосон төлөвлөгөөнд Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажлын төсвийг нэмэгдүүлж 60,000,000 төгрөгөөр баталсан. Батлагдсан төсвийн дагуу ажлын даалгаварыг батлуулж 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зарлагдсан. 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр тендерийн нээлтийг хийж Үнэлгээний хороогоор үнэлэхэд “Такамаса” ХХК шалгарч 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж гэрээний хугацаанд буюу 2024 оны 11 дүгээр сарын 04-нд ажлыг хүлээлгэн өгөх хүсэлт ирүүлсэн. Тус хүсэлтийг үндэслэн 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар Ажил хүлээж авах комисс томилох тухай Засаг даргын захирамжийг гарган 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр комисс бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээж авах шийдвэр гаргаж Ашиглагч байгууллага болох Илчлэг шивээ ОНӨҮГ-т хүлээлгэн өгсөн.</p>	100

							
2.6	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил	7	2024	160,000.0	158,988,4	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажлыг 160,000,000 төгрөгөөр баталсан. 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 4 дэх удаагаа зарлагдсан тендерт “Их хайрханы хишиг” ХХК шалгарч 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. Тус тендерийн ажилд 3 цамхагт гэрэлтүүлгийн ажил хийгдэх бөгөөд цамхаг бүр 360 градусын эргэлттэй шөнийн камержуулалттай байхаар төлөвлөгдөн ажил гүйцэтгэгдэж байна. Гэрээний хугацаа 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр дуусна.</p> <p>Тус ажлын хүрээнд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт Бэхт, Нэрт, Шивээ, Хөтөл, Сүүжийн гудамжуудад 44 гэрэлтүүлгийг шинээр суурьлуулах, сумын төв зам дагуух гэрэлд хээт гэрлэн чимэглэл хийх, Сургуулийн баруун урд, Урд гэр байрны шинэ суурьшлын бүсэд, зүүн гэр байрны урд, Урд гэр</p>	90

						<p>байрны хойд талд 4 ширхэг Цамхагт гэрэлтүүлэг байгуулах, хуучин гэрэлийн шонгуудын ажиллагаагүй болсон гэрэлтүүлгийн 44 толгойг шинэчлэх зэрэг ажлууд хийгдэхээр зураг, техникийн нөхцөл гарсан хийгдэж байна.</p> 	
2.7	Нийтийн эзэмшлийн орон сууцны 3 дугаар байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил	8	2024	150,000.0	147,807.5	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Нийтийн эзэмшлийн 3 дугаар байрны техникийн давхарын шугам сүлжээний их засварын ажил 150,000,000 төгрөгөөр төсвийг баталсан. Тус ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/14 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Засаг даргаар Техникийн тодорхойлолтоо батлуулж нээлттэй тендерийг цахим сайтад зарласан.. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзэхээр худалдахад Такамаса ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж 2024 оны 07 дугаар сарын 03-нд комиссын бүх гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээж авахаар шийдвэрлэсэн.</p> 	100

2.8	Ус хангамжийн нэмэлт эх үүсвэр, шугам сүлжээ автоматжуулалтын ажил	9	2024	380,000.0	375,409,2	<p>2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Ус хангамжийн нэмэлт эх үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил 380,000,000 төгрөгөөр төсвийг баталсан.</p> <p>Тус ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/18 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Засаг даргаар Техникийн тодорхойлолтоо батлуулж нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзэхээр худалдахад Толгод констракшн ХХК шалгарч гэрээ байгуулан ажил эхэлсэн. 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хүлээж авах комисс ажиллаж комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авч оруулж “Илчлэг шивээ” ОНӨҮГ-т хүлээлгэн өгч ажиллалаа.</p>	100
2.9	Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах	10	2024	107,971,7	102,300,0	<p>Төрийн байгууллагуудын шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/12 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Засаг даргаар Техникийн тодорхойлолтоо батлуулж нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзэхээр худалдахад Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Гэрээний хугацаа 2024 оны 06 дугаар сарын 22-нд</p>	100



					<p>дууссан. Гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийг хүлээн авч комиссын бүрэлдэхүүн ашиглагч аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлд хүлээлгэн өгсөн.</p>  <p>"Төрийн байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг"-ыг шийдвэрлэж хүлээлгэж өгсөн байна.</p> <p>"Төрийн байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг"-ыг шийдвэрлэж хүлээлгэж өгсөн байна.</p>		
2.10	Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	11	2024	74,850,0	74,850,0	<p>Сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/22 дугаар Захирамжаар Үнэлгээний хороо байгуулагдаж Сумын аюулгүйн нөөцөд өвс тэжээл худалдан авах ажлын даалгаварыг боловсруулан Засаг даргаар 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр батлуулан Боржигон сансар ХХК, Нарт боржигоны тал ХХК, Очирт хөрс ХХК-уудад үнийн санал, ажлын даалгаварын хамт хүргүүлж ирүүлсэн материалуудыг хянаж үзэхэд шаардлага хангаж байгаа аж ахуйн нэгж гараагүй. Тиймээс газар дээр нь үзэж өвчний чанар, хадгалалт, өнгө, үнэрийг үзэж худалдан авалтыг зохион байгуулахаар 2 аж ахуйн нэгжтэй холбогдож Очирт хөрс ХХК-ийн өвс чанарын шаардлага хангаж байсан тул худалдан авалтыг тус компанитай хийхээр 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулан 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч 04 дүгээр сарын 01-ний өдөр гэрээг дүгнэж хаасан.</p>	100

							
2.11	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний зураг төсөв	12	2024	85,000,0		<p>Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний техникийн нөхцөлийн дагуу ажлын даалгаварыг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Харьцуулалтын аргаар нээлттэй тендерийг зарласан. Тендерийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нээж үнэлгээний хороогоор үнэлэхэд Эрхэс констаркшн ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээг 2024 оны 12 дугаар сарын 06-наас 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулсан. Хийгдэх ажлын зураг төсөв нь магадлалаар орж баталгаажин гарах хугацаа урт учир тус ажил он дамжин хийгдэж байна.</p>	50

2.13	Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц нэмэлтээр бүрдүүлэх ажил	14	2024	51,350,0		<p>2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн ИТХ-ын 05 дугаар тогтоолоор Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц нэмэлтээр бүрдүүлэх ажилд 51,350,000 төгрөгийг төсөвлөн баталсан.</p> <p>Тус ажлыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/125 дугаар захирамжаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Засаг даргаар Ажлын даалгаварыг батлуулж нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Харьцуулалтын аргаар нээлттэй тендерийг зарлан нээсэн. Тус тендерт “Гэрэлт мандал шим” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулсан. 2024 оны 12 дугаар сарын 08-нд 1000 шуудай тэжээлийг комисс ажиллаж хүлээн авсан. Өвс тэжээлийн нөөцийн агуулахад хураалган нөөц бүрдүүлсэн. 2024 оны 12 дугаар 11-ний өдөр 2500 боодол өвсийг комисс ажиллан бүрэн хүлээн авсан.</p>	100
2.14	2025 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар		2024	20,000.0		<p>2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналын дүнгээр шаардлагатай төсөв, тооцооллыг</p>	100



	хэрэгжүүлэх ажлын зураг, төсөв					мэргэшсэн инженер Ц.Адъяатай гэрээ байгуулан хамтран ажиллаж сумын 2025 онд хийгдэх иргэдийн нийтийн саналаар эрэмбэлэгдсэн шаардлагатай 5 ажлын төсвийг хийлгэж хүлээн авсан. Гэрээний хугацаа 2024.12.01 - 2024.12.15 хооронд гүйцэтгэгдсэн.	
--	-----------------------------------	--	--	--	--	--	--

Тайлан хянасан:

Засаг дарга

Ч.Сугармаа

Тайлан бэлтгэсэн:

ХОЭЗТХААХМэргэжилтэн

Д.Баттуул